



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

2026 оны 07 дугаар сарын 09
№26 (1421)

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТАМГЫН ГАЗАР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТАМГЫН ГАЗАР



ГАРЧИГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

109.	Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	1199
110.	Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай	1208
111.	Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	1212

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

112.	Хуулийн төсөл буцаах тухай	Дугаар 26	1213
113.	Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж байгаа төсөл, арга хэмжээний талаар авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай	Дугаар 31	1215
114.	Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай	Дугаар 34	1217
115.	Үндэсний хиймэл дагуул хөөргөх төслийн талаар авах зарим арга хэмжээний тухай	Дугаар 35	1222
116.	Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн гишүүнээр томилох, Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн гишүүнээс чөлөөлөх тухай	Дугаар 42	1231
117.	Сонгуулийн ерөнхий хорооны гишүүнээр томилох, гишүүнээс чөлөөлөх тухай	Дугаар 44	1233
118.	Монголбанкны Тэргүүн дэд ерөнхийлөгчийг томилох тухай	Дугаар 48	1235

[illegible]

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны 06 дугаар
сарын 12-ны өдөр

Улаанбаатар
хот

ЗАМЫН ХӨДӨЛГӨӨНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах зүйл, заалт нэмсүгэй:

1/3 дугаар зүйлийн 3.1.12-3.1.14 дэх заалт:

“3.1.12.“мопед, түүний төрөлд хамаарах скүүтер, тэдгээртэй адилтгах үзүүлэлт бүхий тээврийн хэрэгсэл” гэж 50 куб.см-ээс ихгүй ажлын багтаамж бүхий дотоод шаталтат хөдөлгүүртэй, эсхүл 0.25 кВт-аас 4 кВт хүртэл чадал бүхий цахилгаан хөдөлгүүртэй, техникийн дээд хурд нь цагт 50 км-ээс ихгүй, хоёр, эсхүл хэд хэдэн дугуйтай тээврийн хэрэгслийг;

3.1.13.“нийтийн хэрэгцээний мопед, түүний төрөлд хамаарах скүүтер, тэдгээртэй адилтгах үзүүлэлт бүхий тээврийн хэрэгслийн үйлчилгээ” гэж өөрийн эзэмшлийн тээврийн хэрэгслийг нийтэд төлбөртэйгээр ашиглуулах үйл ажиллагааг;

3.1.14.“нийтийн хэрэгцээний мопед, түүний төрөлд хамаарах скүүтер, тэдгээртэй адилтгах үзүүлэлт бүхий тээврийн хэрэгслийн үйлчилгээ үзүүлэгч” гэж өөрийн эзэмшлийн тээврийн хэрэгслийг гэрээний үндсэн дээр хэрэглэгчид тодорхой хугацаагаар, төлбөртэйгээр ашиглуулах үйл ажиллагааг эрхлэн явуулдаг хуулийн этгээдийг.”

2/11¹ дүгээр зүйл:

**“11¹ дүгээр зүйл.Нийтийн хэрэгцээний мопед, түүний төрөлд
хамаарах скүүтер, тэдгээртэй адилтгах
үзүүлэлт бүхий тээврийн хэрэгслийн
үйлчилгээний хяналт, зохицуулалт**

11¹.1.Нийтийн хэрэгцээний мопед, түүний төрөлд хамаарах скүүтер, тэдгээртэй адилтгах үзүүлэлт бүхий тээврийн хэрэгслийн үйлчилгээ үзүүлэгч нь аймаг, нийслэлийн Засаг даргатай байгуулсан гэрээний үндсэн дээр үйл ажиллагаа эрхэлнэ.



11^{1.2}.Энэ хуулийн 11^{1.1}-д заасан гэрээнд нийтийн хэрэгцээний мопед, түүний төрөлд хамаарах скүүтер, тэдгээртэй адилтгах үзүүлэлт бүхий тээврийн хэрэгслийн үйлчилгээ үзүүлэгчийн үйл ажиллагаа эрхлэхтэй холбоотой төлбөр, хураамж, зорчих бүсчлэлт, зогсоолын талбайн байршил зэрэг талуудын эрх, үүргийн харилцааг зохицуулсан байна.

11^{1.3}.Нийтийн хэрэгцээний мопед, түүний төрөлд хамаарах скүүтер, тэдгээртэй адилтгах үзүүлэлт бүхий тээврийн хэрэгслийн үйлчилгээ үзүүлэгч нь энэ хуулийн 11^{1.1}-д заасан гэрээний нөхцөл, шаардлагыг хангаж ажиллаагүй бол аймаг, нийслэлийн Засаг дарга үйл ажиллагааг нь түр хязгаарлах, эсхүл гэрээг цуцлах арга хэмжээг авна.”

3/12¹ дүгээр зүйл:

“12¹ дүгээр зүйл.Мопед, түүний төрөлд хамаарах скүүтер, тэдгээртэй адилтгах үзүүлэлт бүхий тээврийн хэрэгслээр замын хөдөлгөөнд оролцогчийн эрх, үүрэг

12^{1.1}.Мопед, түүний төрөлд хамаарах скүүтер, тэдгээртэй адилтгах үзүүлэлт бүхий тээврийн хэрэгслээр замын хөдөлгөөнд оролцогчийн энэ хуульд тусгайлан зааснаас бусад эрх, үүргийг Замын хөдөлгөөний дүрэм болон холбогдох хуульд заасан журмын дагуу зохицуулна.

12^{1.2}.Монгол Улсын нутаг дэвсгэрт мопед, түүний төрөлд хамаарах скүүтер, тэдгээртэй адилтгах үзүүлэлт бүхий тээврийн хэрэгслийг 18 буюу түүнээс дээш насны хүн жолоодож замын хөдөлгөөнд оролцох эрхтэй.

12^{1.3}.Мопед, түүний төрөлд хамаарах скүүтер, тэдгээртэй адилтгах үзүүлэлт бүхий тээврийн хэрэгслийн жолооч нь энэ хуулийн 14.2-т заасан тээврийн хэрэгслийн жолооч бэлтгэх журам, сургалтын хөтөлбөрийн дагуу сургалтад хамрагдаж, жолооч бэлтгэх сургалтын байгууллагын бүртгэл, мэдээллийн санд бүртгүүлсэн байна.

12^{1.4}.Мопед, түүний төрөлд хамаарах скүүтер, тэдгээртэй адилтгах үзүүлэлт бүхий тээврийн хэрэгслийн эзэмшигч нь тээврийн хэрэгслээ Автотээврийн тухай хуулийн 17^{1.2}-т заасан журмын дагуу бүртгүүлэх үүрэгтэй.

12^{1.5}.Эцэг, эх, асран хамгаалагч нь 18 нас хүрээгүй хүүхдийг мопед, түүний төрөлд хамаарах скүүтер, тэдгээртэй адилтгах үзүүлэлт бүхий тээврийн хэрэгсэл жолоодон замын хөдөлгөөнд оролцуулахгүй байх үүрэгтэй.”

4/13¹ дүгээр зүйл:

“13¹ дүгээр зүйл.Нийтийн хэрэгцээний мопед, түүний төрөлд хамаарах скүүтер, тэдгээртэй адилтгах үзүүлэлт бүхий тээврийн хэрэгслийн үйлчилгээ үзүүлэгчийн эрх, үүрэг

13¹.1.Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах талаар нийтийн хэрэгцээний мопед, түүний төрөлд хамаарах скүүтер, тэдгээртэй адилтгах үзүүлэлт бүхий тээврийн хэрэгслийн үйлчилгээ үзүүлэгч нь дараах эрх эдэлнэ:

13¹.1.1.үйлчилгээний нөхцөл, үнэ тарифаа өөрөө тогтоох;

13¹.1.2.замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах талаар төрийн болон төрийн бус байгууллага, иргэнтэй хамтран ажиллах.

13¹.2.Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах талаар нийтийн хэрэгцээний мопед, түүний төрөлд хамаарах скүүтер, тэдгээртэй адилтгах үзүүлэлт бүхий тээврийн хэрэгслийн үйлчилгээ үзүүлэгч нь дараах үүргийг хүлээнэ:

13¹.2.1.энэ хуульд заасан замын хөдөлгөөний аюулгүй байдлын үндсэн шаардлага, зохих стандартад нийцсэн мопед, түүний төрөлд хамаарах скүүтер, тэдгээртэй адилтгах үзүүлэлт бүхий тээврийн хэрэгслээр үйлчилгээ үзүүлэх;

13¹.2.2.өөрийн эзэмшлийн мопед, түүний төрөлд хамаарах скүүтер, тэдгээртэй адилтгах үзүүлэлт бүхий тээврийн хэрэгслийг бүртгүүлэх;

13¹.2.3.эрх бүхий этгээдээс тогтоосон зогсоолын байршлаас бусад нийтийн эзэмшлийн зам, гудамж, талбай, нийтийн амралт, зугаалга, биеийн тамирын зориулалттай газар, цэцэрлэгт хүрээлэн, авто зогсоол, ногоон байгууламж, нийтийн зориулалттай орон сууцны байшингийн орчны газрын ногоон зүлэг, хүүхдийн тоглоомын талбай, эдгээртэй адилтгах газарт мопед, түүний төрөлд хамаарах скүүтер, тэдгээртэй адилтгах үзүүлэлт бүхий тээврийн хэрэгсэл байршуулахгүй байх;

13¹.2.4.мэдээллийн эзний зөвшөөрлөөр хүний хувийн мэдээллийг цуглуулах, боловсруулах, ашиглах;

13¹.2.5.мопед, түүний төрөлд хамаарах скүүтер, тэдгээртэй адилтгах үзүүлэлт бүхий тээврийн хэрэгслийн батарей, бусад аюултай хог хаягдлыг эрх бүхий байгууллагад, эсхүл тогтоосон тусгай цэгт хүлээлгэн өгөх;



13¹.2.6.иргэдэд замын хөдөлгөөнд аюулгүй оролцохыг сурталчлах;

13¹.2.7.18 нас хүрээгүй хүүхэд болон энэ хуулийн 12¹.3-т заасан сургалтад хамрагдаж, бүртгүүлээгүй хүнийг мопед, түүний төрөлд хамаарах скүүтер, тэдгээртэй адилтгах үзүүлэлт бүхий тээврийн хэрэгсэл жолоодож замын хөдөлгөөнд оролцуулахгүй байх технологийн арга хэмжээ авах;

13¹.2.8.нийтийн хэрэгцээний мопед, түүний төрөлд хамаарах скүүтер, тэдгээртэй адилтгах үзүүлэлт бүхий тээврийн хэрэгслийн үйлчилгээ үзүүлэгч нь энэ хуульд заасан үүргээ биелүүлээгүйгээс бусдын амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөд учирсан хохирлыг нөхөн төлөх зорилгоор хариуцлагын даатгалд хамрагдах.”

2 дугаар зүйл.Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.2 дахь заалтын “мопедоос” гэснийг “мопед, түүний төрөлд хамаарах скүүтер, тэдгээртэй адилтгах үзүүлэлт бүхий тээврийн хэрэгслээс” гэж, мөн зүйлийн 3.1.11 дэх заалтын “мопед” гэснийг “мопед, түүний төрөлд хамаарах скүүтер, тэдгээртэй адилтгах үзүүлэлт бүхий тээврийн хэрэгсэл” гэж өөрчилсүгэй.

3 дугаар зүйл.Энэ хуулийн 1 дүгээр зүйлийн 3 дахь заалтын 12¹ дүгээр зүйлийн 12¹.4 дэх хэсэг болон мөн зүйлийн 4 дэх заалтын 13¹ дүгээр зүйлийн 13¹.2.8 дахь заалтыг 2026 оны 06 дугаар сарын 30-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

С.БЯМБАЦОГТ

Бусдын үзүүлэлтүүд

Бусдын үзүүлэлтүүд

Бусдын үзүүлэлтүүд - бусдын үзүүлэлтүүд

Бусдын үзүүлэлтүүд - бусдын үзүүлэлтүүд
Бусдын үзүүлэлтүүд - бусдын үзүүлэлтүүд

Бусдын үзүүлэлтүүд - бусдын үзүүлэлтүүд
Бусдын үзүүлэлтүүд - бусдын үзүүлэлтүүд

Бусдын үзүүлэлтүүд - бусдын үзүүлэлтүүд

Бусдын үзүүлэлтүүд - бусдын үзүүлэлтүүд
Бусдын үзүүлэлтүүд - бусдын үзүүлэлтүүд

Бусдын үзүүлэлтүүд - бусдын үзүүлэлтүүд
Бусдын үзүүлэлтүүд - бусдын үзүүлэлтүүд

Бусдын үзүүлэлтүүд - бусдын үзүүлэлтүүд
Бусдын үзүүлэлтүүд - бусдын үзүүлэлтүүд

Бусдын үзүүлэлтүүд - бусдын үзүүлэлтүүд

[illegible][illegible][illegible][illegible]

26/٥
حصن
حصن

«سَکَرُ کُتْرُنْ لَهْکَرُ .. نَسْکَرُ لَهْ لَهْکَرِکِرِ وِ رَهْکَرِکِرِ . مَهْکَرِ وِ مَهْکَرِکِرِ کَوِ
لَهْکَرِکِرِ مَهْکَرِکِرِ . مَهْکَرِکِرِ مَهْ لَهْکَرِکِرِکِرِ مَهْکَرِکِرِکِرِ مَهْکَرِکِرِکِرِ
مَهْکَرِکِرِکِرِ لَهْ لَهْکَرِکِرِکِرِ مَهْکَرِکِرِکِرِ لَهْ لَهْکَرِکِرِکِرِ . مَهْکَرِکِرِ

[illegible][illegible][illegible][illegible]

[illegible][illegible]

کتاب الفصحی فی
اصول الفصحی

ሥ.፡፪፻፳፱



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны 06 дугаар
сарын 12-ны өдөр

Улаанбаатар
хот

ЗӨРЧЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Зөрчлийн тухай хуулийн 14.7 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай дараах 59, 60, 61, 62 дахь хэсэг нэмсүгэй:

“59.Мопед, түүний төрөлд хамаарах скүүтер, тэдгээртэй адилтгах үзүүлэлт бүхий тээврийн хэрэгслийг жолоодож явган хүний гарцаар зам хөндлөн гарсан бол хүнийг тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

60.Мопед, түүний төрөлд хамаарах скүүтер, тэдгээртэй адилтгах үзүүлэлт бүхий тээврийн хэрэгслийг жолоодон замын хөдөлгөөнд оролцсон арван найман нас хүрээгүй хүүхдийн эцэг, эх, асран хамгаалагчийг хоёр зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

61.Нийтийн хэрэгцээний мопед, түүний төрөлд хамаарах скүүтер, тэдгээртэй адилтгах үзүүлэлт бүхий тээврийн хэрэгслийн үйлчилгээ үзүүлэгч хуулийн этгээд:

61.1.өөрийн эзэмшлийн мопед, түүний төрөлд хамаарах скүүтер, тэдгээртэй адилтгах үзүүлэлт бүхий тээврийн хэрэгслийг бүртгүүлээгүй;

61.2.арван найман нас хүрээгүй хүүхэд болон Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн 14.2-т заасан сургалтад хамрагдаагүй хүнийг мопед, түүний төрөлд хамаарах скүүтер, тэдгээртэй адилтгах үзүүлэлт бүхий тээврийн хэрэгсэл жолоодож замын хөдөлгөөнд оролцуулахгүй байх технологийн арга хэмжээ авах хуулиар хүлээсэн үүргээ биелүүлээгүй бол таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

62.Нийтийн хэрэгцээний мопед, түүний төрөлд хамаарах скүүтер, тэдгээртэй адилтгах үзүүлэлт бүхий тээврийн хэрэгслийн үйлчилгээ үзүүлэгч хуулийн этгээд нь эрх бүхий этгээдээс тогтоосон зогсоолын байршлаас бусад нийтийн эзэмшлийн зам, гудамж, талбай, нийтийн амралт, зугаалга, биеийн тамирын зориулалттай газар, цэцэрлэгт хүрээлэн, авто зогсоол, ногоон байгууламж, нийтийн зориулалттай орон сууцны байшингийн орчны газрын ногоон зүлэг, хүүхдийн тоглоомын талбай, эдгээртэй адилтгах газарт тээврийн хэрэгслээ байршуулсан бол тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.”



2 дугаар зүйл.Энэ хуулийг 2026 оны 06 дугаар сарын 12-ны өдөр баталсан Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

С.БЯМБАЦОГТ

дэгдэх явдал нь хамгийн ихдээ 100 - 150 г хүртэл байдаг.

Хамгийн ихдээ 100 - 150 г хүртэл байдаг хүлээх хамгийн ихдээ 100 - 150 г хүртэл байдаг

Хүлээх хамгийн ихдээ 100 - 150 г хүртэл байдаг. Хүлээх хамгийн ихдээ 100 - 150 г хүртэл байдаг. Хүлээх хамгийн ихдээ 100 - 150 г хүртэл байдаг.

Хүлээх хамгийн ихдээ 100 - 150 г хүртэл байдаг. Хүлээх хамгийн ихдээ 100 - 150 г хүртэл байдаг. Хүлээх хамгийн ихдээ 100 - 150 г хүртэл байдаг.

Хүлээх хамгийн ихдээ 100 - 150 г хүртэл байдаг. Хүлээх хамгийн ихдээ 100 - 150 г хүртэл байдаг. Хүлээх хамгийн ихдээ 100 - 150 г хүртэл байдаг.

Хүлээх хамгийн ихдээ 100 - 150 г хүртэл байдаг. Хүлээх хамгийн ихдээ 100 - 150 г хүртэл байдаг. Хүлээх хамгийн ихдээ 100 - 150 г хүртэл байдаг.

Хүлээх хамгийн ихдээ 100 - 150 г хүртэл байдаг. Хүлээх хамгийн ихдээ 100 - 150 г хүртэл байдаг. Хүлээх хамгийн ихдээ 100 - 150 г хүртэл байдаг.

Хүлээх хамгийн ихдээ 100 - 150 г хүртэл байдаг. Хүлээх хамгийн ихдээ 100 - 150 г хүртэл байдаг. Хүлээх хамгийн ихдээ 100 - 150 г хүртэл байдаг.

Хүлээх хамгийн ихдээ 100 - 150 г хүртэл байдаг. Хүлээх хамгийн ихдээ 100 - 150 г хүртэл байдаг. Хүлээх хамгийн ихдээ 100 - 150 г хүртэл байдаг.

[illegible][illegible]

ՀԱՅԿԱՅԻՆ ԲԱՆԿ

ሥ. ሳ. ም. ም.

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны 06 дугаар
сарын 19-ний өдөр

Улаанбаатар
хот

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН
ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ
ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн “4 жил” гэснийг “6 жил” гэж өөрчилсүгэй.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

С.БЯМБАЦОГТ

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ-ᠤᠨ ᠬᠤᠠᠭᠤᠯᠤᠰ

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ-ᠤᠨ ᠶᠡᠷᠦᠨᠬᠡᠢᠯᠡᠭᠴᠢᠨ ᠤᠨ ᠬᠤᠠᠭᠤᠯᠤᠰ

ᠲᠤᠬᠤᠠᠢ ᠬᠤᠠᠭᠤᠯᠤᠰ-ᠤᠨ ᠖ᠣᠳᠤᠭᠠᠭ ᠵᠢᠢᠯᠢᠢᠨ 1ᠣᠳᠤᠭ ᠬᠡᠰᠦᠭᠢᠨ “4ᠣ ᠵᠢᠯ” ᠭᠡᠰᠢᠨᠢᠭ “6ᠣ ᠵᠢᠯ” ᠭᠡᠭᠡᠷᠴᠢᠯᠰᠦᠭᠡᠢ.

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ-ᠤᠨ
ᠶᠡᠬᠡ ᠬᠤᠷᠯ-ᠤᠨ ᠳᠠᠷᠭ᠋᠎ᠠ

ᠰ.ᠪᠢᠶ᠋ᠮᠪᠠᠴᠣᠭᠲᠤ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2026 оны 05 дугаар
сарын 29-ний өдөр

Дугаар 26

Улаанбаатар
хот

Хуулийн төсөл буцаах тухай

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.12 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Монгол Улсын Их Хурлын гишүүн П.Батчимэг нарын 9 гишүүнээс 2025 оны 07 дугаар сарын 03-ны өдөр Монгол Улсын Улсын Их Хуралд Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг Байнгын хороо буцаах нь зүйтэй гэсэн санал, дүгнэлт гаргасныг нэгдсэн хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул хууль санаачлагчид буцаасугай.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

С.БЯМБАЦОГТ

[illegible]

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2026 оны 06 дугаар
сарын 04-ний өдөр

Дугаар 31

Улаанбаатар
хот

Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж байгаа төсөл, арга хэмжээний талаар авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.4 дэх заалтыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Улс, орон нутгийн төсөв, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн хөрөнгө оруулалт /цаашид "төсвийн хөрөнгө оруулалт" гэх/-аар болон Засгийн газрын гадаад зээлийн эх үүсвэрээр хэрэгжүүлж байгаа төсөл, арга хэмжээний талаар дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Н.Учрал/-т даалгасугай:

1/төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж эхэлсэн боловч бүрэн дуусаагүй зогссон төсөл, арга хэмжээний ашиглалтад ороогүй шалтгаан, төсөвт үзүүлж байгаа үр дагавар, нөлөөллийг төсөл, арга хэмжээ нэг бүрээр судалж, холбогдох тайлан болон цаашид төсвийн хөрөнгө оруулалтаар үргэлжлүүлэх, эсхүл өмчлөлийн өөр хэлбэрт шилжүүлэх зэрэг асуудлаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний саналаа 2026 оны 09 дүгээр сарын 15-ны дотор Улсын Их Хуралд танилцуулах;

2/Засгийн газрын гадаад зээлийн эх үүсвэрээр хэрэгжүүлж эхэлсэн боловч зээлийн хэлэлцээрийн хугацаанд бүрэн дуусах боломжгүй зогссон төсөл, арга хэмжээний талаарх мэдээллийг энэ тогтоолын 1.1 дэх дэд заалтад заасан тайланд тусгах;

3/Улсын Их Хурлаар жилийн төсвийн төслийг хэлэлцэх хэлэлцүүлгийн бүх шатанд Төсвийн тухай хуулийн 29^{1.4}-т заасан цахим систем дэх мэдээллээс улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний санал авах, үнэлэх, эрэмбэлэх, төлөвлөх, батлах үйл явцыг Улсын Их Хурлын гишүүд нээлттэй харах боломжийг бүрдүүлэх.

2.Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Их Хурлын Төсвийн байнгын хороо /Н.Наранбаатар/-нд даалгасугай.

3.Энэ тогтоолыг 2026 оны 06 дугаар сарын 04-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

С.БЯМБАЦОГТ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2026 оны 06 дугаар
сарын 12-ны өдөр

Дугаар 34

Улаанбаатар
хот

**Замын хөдөлгөөний аюулгүй байдлын
тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах
тухай хууль баталсантай холбогдуулан
авах зарим арга хэмжээний тухай**

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.5 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль баталсантай холбогдуулан дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар (Н.Учрал), Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч (Б.Пүрэвдагва)-д даалгасугай:

1/Монгол Улсын Замын хөдөлгөөний дүрэм, түүнчлэн мопед, түүний төрөлд хамаарах скүүтер, тэдгээртэй адилтгах техникийн үзүүлэлт бүхий тээврийн хэрэгслийн ангилал, техникийн шаардлага, стандартыг хуульд нийцүүлэн шинэчлэн боловсруулж батлах;

2/мопед, түүний төрөлд хамаарах скүүтер, тэдгээртэй адилтгах тээврийн хэрэгслийг “Автотээврийн хэрэгслийн бүртгэл хөтлөх, улсын дугаар олгох журам”-д хамруулан бүртгэлжүүлэх эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгож, холбогдох журмыг 2026 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн дотор шинэчлэн батлах;

3/нийтийн хэрэгцээний мопед, түүний төрөлд хамаарах скүүтер, тэдгээртэй адилтгах тээврийн хэрэгслийн үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагааг Зөвшөөрлийн тухай хуульд нийцүүлэн энгийн зөвшөөрөл, эсхүл мэдэгдлийн хэлбэрээр эрхлэх эсэхийг тодорхойлж, шаардлагатай гэж үзсэн нөхцөлд үйлчилгээ эрхлэгчид тавих тусгай нөхцөл, шаардлага, хяналт шалгалт, зөрчил шалган шийдвэрлэх харьяаллыг тодорхойлсон холбогдох хууль тогтоомжийн төслийн хамт цогцоор нь боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх;

4/мопед, түүний төрөлд хамаарах скүүтер, тэдгээртэй адилтгах үзүүлэлт бүхий тээврийн хэрэгслийн явган хүний замаар зорчих хөдөлгөөнийг хязгаарлахтай холбогдуулан унадаг дугуйн зам, эгнээг хөгжүүлэх, зорчих хэсгийн баруун хөвөөгөөр аюулгүй зорчих нөхцөлийг бүрдүүлэх, хөдөлгөөний урсгалаас тусгаарлах хашлага, тэмдэг, тэмдэглэлийг стандартын дагуу байрлуулах, зориулалтын зогсоолын талбайг нэмэгдүүлэх зэрэг арга хэмжээг нэн даруй авч хэрэгжүүлэх;



5/энэ тогтоолын хэрэгжилттэй холбогдуулан өмнө нь ашиглалт, үйлчилгээнд орсон мопед, түүний төрөлд хамаарах скүүтер, тэдгээртэй адилтгах үзүүлэлт бүхий тээврийн хэрэгслийг 2026 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн дотор бүртгэлд хамруулах ажлыг зохион байгуулах;

6/мопед, түүний төрөлд хамаарах скүүтер, тэдгээртэй адилтгах тээврийн хэрэгслээр замын хөдөлгөөнд аюулгүй оролцох, хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2 дахь хэсэгт заасан холбогдох журам, сургалтын хөтөлбөрийг 2026 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн дотор шинэчлэн батлах, Замын хөдөлгөөний дүрэмд заасан жолоодох эрхийн үнэмлэх бүхий иргэн тухайн сургалтад дүйцүүлэн тооцогдохоор зохион байгуулах;

7/тухайн нутаг дэвсгэрийн онцлогт нийцүүлэн мопед, түүний төрөлд хамаарах скүүтер, тэдгээртэй адилтгах үзүүлэлт бүхий тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг зохицуулах журмыг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн баталж мөрдүүлэх, шаардлагатай тохиолдолд эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох санал боловсруулж Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх;

8/замын хөдөлгөөний аюулгүй байдлын талаарх олон нийтийн мэдлэг, хэрэглээний соёлыг төлөвшүүлэх сургалт, мэдээллийн ажлыг зохион байгуулах;

9/хяналт шалгалтыг хэрэгжүүлэх эрх бүхий байгууллагын чиг үүрэг, хамтын ажиллагааг тодорхой болгож, зөрчил илрүүлэх, таслан зогсоох арга хэмжээг үр нөлөөтэй зохион байгуулах.

2.Энэ тогтоолд заасан арга хэмжээний биелэлтийн тайланг Монгол Улсын Их Хурлын 2026 оны намрын ээлжит чуулганы хугацаанд багтаан Улсын Их Хуралд ирүүлэхийг Монгол Улсын Засгийн газар (Н.Учрал), Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч (Б.Пүрэвдагва)-д даалгасугай.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хороо (Д.Цогтбаатар)-нд даалгасугай.

4.Энэ тогтоолыг 2026 оны 06 дугаар сарын 12-ны өдөр баталсан Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

С.БЯМБАЦОГТ

[illegible]

[illegible][illegible][illegible]

کتابت از کتابخانه
مکتبہ اسلامیہ

ሥ. ገብረመስቀል



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2026 оны 06 дугаар
сарын 12-ны өдөр

Дугаар 35

Улаанбаатар
хот

Үндэсний хиймэл дагуул хөөргөх төслийн талаар авах зарим арга хэмжээний тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэг, 27 дугаар зүйлийн 27.2 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Үндэсний хиймэл дагуул хөөргөх төслийн талаар дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Н.Учрал/-т даалгасугай:

1/Монгол Улсын өнөөгийн болон ирээдүйн хэрэгцээ, аюулгүй байдлын шаардлагад нийцсэн, орчин үеийн технологийн шийдлийг нэвтрүүлсэн, дамжуулах хүчин чадал, нийт өртөг, санхүүжилтийн нөхцөл, хэрэгжих хугацаа, ашиглалтын үр өгөөжийг зах зээлийн боломж, чадавхад нийцүүлэн тооцсон байдлаар үндэсний хиймэл дагуул хөөргөх төслийн техник, эдийн засгийн үндэслэлийг шинэчлэн боловсруулах;

2/үндэсний хиймэл дагуул хөөргөх төсөл хэрэгжүүлэгчийг сонгон шалгаруулахдаа дамжуулах хүчин чадал, санхүүжилтийн нөхцөл, зардал, хэрэгжих хугацаа, хөөргөлт, даатгал, газрын станц, сургалт, зөвлөх үйлчилгээ, ашиглалт, засвар үйлчилгээ, сансрын ашигтай байрлал болон ашиглалтын үр өгөөж зэрэг нийт эзэмшлийн өртгөөр үнийн шалгуурыг гаргаж, олон улсын зах зээл дээр санал болгож байгаа боломжит хувилбаруудыг харьцуулан судалж, сонгон шалгаруулалтыг ил тод явуулах;

3/үндэсний хиймэл дагуул хөөргөх төслийн санхүүжилтийг Монгол Улсын төсөв, гадаад өрийн хэмжээнд дарамт учруулахгүй байх чиглэлээр урт хугацаатай, нэн хөнгөлөлттэй зээл, экспортын санхүүжилт, лизинг, ашиглалтын орлогоор эргэн төлөх зэрэг санхүүжилтийн уян хатан хувилбаруудыг судалж, хэрэгжүүлэх боломжийг бүрдүүлэх.

2.Энэ тогтоолын 1 дэх заалтад заасан арга хэмжээний хэрэгжилтийн үр дүнг тооцох шалгуур үзүүлэлтийг хавсралтаар баталсугай.

3.Энэ тогтоолын хэрэгжилтийг Монгол Улсын Их Хурлын 2027 оны хаврын ээлжит чуулганы хугацаанд Монгол Улсын Их Хуралд танилцуулахыг Монгол Улсын Засгийн газар /Н.Учрал/-т даалгасугай.

4.Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хороо /Б.Заяабал/-нд даалгасугай.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

С.БЯМБАЦОГТ

АРГА ХЭМЖЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТИЙН ҮР ДҮНГ ТООЦОХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

Д/д	Тогтоолын дэд заалт	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин 2026 он	Хүрэх түвшин 2027 он	Хүрэх үр дүн	Хариуцах байгууллага	Мэдээллийн эх сурвалж
1	1.1/Монгол Улсын өнөөгийн болон ирээдүйн хэрэгцээ, аюулгүй байдлын шаардлагад нийцсэн, орчин үеийн технологийн шийдлийг нэвтрүүлсэн, дамжуулах хүчин чадал, нийт өртөг, санхүүжилтийн нөхцөл, хэрэгжих хугацаа, ашиглалтын үр өгөөжийг зах зээлийн болгож, чадаахад нийцүүлэн тооцсон байдлаар үндэсний хиймэл дагуул хөөргөх төслийн техник, эдийн засгийн үндэслэлийг шинэчлэн боловсруулах;	Харилцаа холбоо, гал орчмын болон гамшигын үеийн холбоо, аюулгүй өргөн байдал, хэрэгцээний зурвасын хэрэглээний 10-15 жилийн өсөлтийн тооцоо.	2011-2013 онд хийгдсэн техник, эдийн засгийн үндэслэл тооцоолон, технологийн шийдэл хуучирсан.	Шинэчилсэн техник, эдийн засгийн үндэслэл хэрэгцээ, цаг үеийн шаардлагад нийцсэн, орчин үеийн технологийн нэн шинэ шийдлүүдийг судалсан байх.	Шинэчилсэн техник, эдийн засгийн үндэслэл	Засгийн газар	Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам, Сангийн яам, Эдийн засаг, хөгжлийн яам
		Анхны болон өргөтгөх боломжит дамжуулах хүчин чадал, Гб/сек.	Нийт дамжуулах хүчин чадал 10.3 Гб/сек байгаа. Нэмэлт бүртгэлээр 21-30 Гб/сек хүртэл нэмэх боломж судлагдаж байна.	Анхны ашиглалтын үед хамгийн багадаа 50 Гб/сек, цаашид дамгаж технологийн хувьд өргөтгөх боломжийн техник, эдийн засгийн үндэслэл тусгасан байх.	Техникийн шаардлага, сулжээний давамгайлын нотлоого	Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам	Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам
		Ku, Ka band /цараа/ болон бусад боломжит давтамжийн зурвас, 113.6°E байрлалын болон нэмэлт давтамж ашиглах боломжийн үнэлгээ.	113.6°E байрлалд Ku-band давтамжийн зурвас 113.6°E байрлалын хязгаарлагдмал.	113.6°E давтамжийн нөөцийг бүрэн ашиглах, мөн нэмэлт давтамж ашиглах хувилбар туссан байх.	Давтамжийн төлөвлөлт, олон улсын зохицуулалтын дүгнэлт	Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам, Харилцаа холбооны зохицуулах хороо	Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам, Харилцаа холбооны зохицуулах хороо
		- Өндөр нууцлалтай модуляц, шифрлэлтийн дэмжлэг, - кибер аюулгүй байдал, өгөгдлийн бүрэн эрхт байдлын үнэлгээ.	Бүрэн судлагдаагүй.	Аюулгүй байдлын шаардлага модуляц, шифрлэлт үндсэн шийдэлд багтсан, үндэсний аюулгүй байдлын нөлөөллийн үнэлгээ, кибер аюулгүй байдал, өгөгдлийн бүрэн эрхт байдлын үнэлгээ хийгдсэн байх.	Аюулгүй байдлын дүгнэлт, техникийн тодорхойлолт	Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам, Батлан хамгаалах	Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам, Хууль зүй, дотоод хэргийн яам, Тэнгүүн ерөнхий газар



2	1.2/үндэсний хиймэл дагуул хөөрөх төсөл хэрэгжүүлэгчийг сонгон шалгаруулахдаа дамжуулах хүчин чадал, санхүүжилтийн нөхцөл, зардал, хэрэгжих хугацаа, хөөрөг, даатгал, газрын станц, сургалт, зөвлөх үйлчилгээ, ашиглалт, засвар үйлчилгээ, сансрын ашигтай байрлал болон ашиглалтын үр өгөөж зэрэг нийт эзэмшлийн өртгөөр үнийн шалгуурыг гаргаж, олон улсын зах зээл дээр санал болгож байгаа боломжит хувилбаруудыг харьцуулан судалж, сонгон шалгаруулалтыг ил тод явуулах;	- Техникийн болон санхүүгийн санал ирүүлсэн эрх бүхий олон улсын компанийн тоо; - үнэлгээний аргачлал урьдчилан батлагдсан; - онооны задаргаа, жин, хасах босго; - ашиг сонирхлын зөрчлийн мэдүүлэгтэй байх.	Нэг компанид төвлөрсөн, харьцуулсан саналуд бүрэн тусгагдаагүй.	5-аас доошгүй эрх бүхий олон улсын оролцогчтой, техникийн болон саналыг харьцуулсан байх.	Техникийн болон санхүүгийн саналын үнэлгээний тайлан /Сонгон шалгаруулалтаас өмнө/	Засгийн газар	Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам, Төрийн худалдан авах ажиллагааны газар
3	1.3/төслийн санхүүжилтийг Монгол Улсын төсөв, гадаад өрийн хэмжээнд дарамт учруулахгүй байх чиглэлээр урт сургалт, зөвлөх хугацаатай, нэн хөнгөлөлттэй зээл, экспортын санхүүжилт, лизинг, ашиглалтын орлогоор эргэн төлөх зэрэг санхүүжилтийн уян хатан хувилбаруудыг судалж, хэрэгжүүлэх боломжийг бүрдүүлэх.	Хиймэл дагуул, даатгал, хөөрөг, газрын станц, gateway, сургалт, зөвлөх үйлчилгээ, хүүгийн зардлыг багтаасан байх.	Одоогийн харьцуулалтад хиймэл дагуулын үнэ, нэмэлт зардлууд сапанид.	- Бүх саналыг нийт эзэмшлийн өртгөөр нэг аргачлалаар тооцож, 15 жилийн амьдралын мөчлөгийн зардал/үр өгөөж гаргасан байх; - нийт үнэ 100-150 сая ам.долларт багтсан байх.	Тооцооны хүснэгт, санхүүгийн загвар	Сангийн яам, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам	Сангийн яам, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам
		Өрийн тогтвортой байдлын шинжилгээ, улсын төсөвт шууд ачаалал үүсгэх эсэх, эргэн төлөлтийн эх үүсвэртэй байх.	310.8 сая евро орчим хөрөнгө оруулалт нь төсөв, гадаад лизинг, өрийн дарамт үүсгэх эргэн төлөх харьцуулан судалж, төсөв өрийн дарамтгүй хувилбар санал болгосон байх.	Нэн хөнгөлөлттэй зээл, экспортын санхүүжилт, орлогоор эргэн төлөх загварыг харьцуулан судалж, төсөв өрийн дарамтгүй хувилбар санал болгосон байх.	Өрийн шинжилгээ, санхүүжилтийн хувилбарын дүгнэлт, техник, эдийн засгийн үндэслэл багтагдсанаас хойш 120 хоногт/	Сангийн яам, Эдийн засаг, хөгжлийн яам	Сангийн яам, Эдийн засаг, хөгжлийн яам
		Илүүдэл хүчин чадал борлуулах, төрийн хэрэглээний хэмнэлт, хувийн хэвшлийн хэрэглээний орлогын тооцоо.	Орлогын загвар тодорхой бүс.	15 жилийн орлого, хэрэглээ, эрэлт, зах зээлийн эрсдэлийн тооцоо туссан, мэдрэмжийн шинжилгээтэй байх.	Орлого/эрэлт, мэдрэмжийн шинжилгээ /Техник, эдийн засгийн үндэслэл багтагдсанаас хойш 120 хоногт/	Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам, Сангийн яам	Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам, Сангийн яам

---ООо---

[illegible]

[illegible][illegible]

١٠. من مضمون من النص هو انفسه
١١. من مضمون من النص هو انفسه
١٢. من مضمون من النص هو انفسه
١٣. من مضمون من النص هو انفسه
١٤. من مضمون من النص هو انفسه
١٥. من مضمون من النص هو انفسه
١٦. من مضمون من النص هو انفسه
١٧. من مضمون من النص هو انفسه
١٨. من مضمون من النص هو انفسه
١٩. من مضمون من النص هو انفسه
٢٠. من مضمون من النص هو انفسه

کتابخانه عمومی
مکتبہ اسلامیہ

ሥ. ሳ. ም. ም.

1229

[illegible]

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2026 оны 06 дугаар
сарын 26-ны өдөр

Дугаар 42

Улаанбаатар
хот

**Монгол Улсын Үндсэн хуулийн
цэцийн гишүүнээр томилох,
Монгол Улсын Үндсэн хуулийн
цэцийн гишүүнээс чөлөөлөх тухай**

Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран тавдугаар зүйлийн 1, 2 дахь хэсэг, Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 4 дүгээр зүйлийн 1, 2 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 104 дүгээр зүйлийн 104.2 дахь хэсэг, 105 дугаар зүйлийн 105.2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Монгол Улсын Их Хурлын санал болгосноор Жамъянхорлоогийн Сүхбаатар, Ганбатын Эрдэнэбат нарыг Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн гишүүнээр томилсугай.

2.Бүрэн эрхийн хугацаа нь дуусгавар болсон тул Гунгаагийн Баясгаланг Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн гишүүнээс чөлөөлсүгэй.

3.Энэ тогтоолыг 2026 оны 06 дугаар сарын 26-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

С.БЯМБАЦОГТ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2026 оны 06 дугаар
сарын 30-ны өдөр

Дугаар 44

Улаанбаатар
хот

Сонгуулийн ерөнхий хорооны гишүүнээр томилох, гишүүнээс чөлөөлөх тухай

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 111 дүгээр зүйлийн 111.2 дахь хэсэг, Сонгуулийн төв байгууллагын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2, 4.5 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Сонгуулийн ерөнхий хорооны гишүүнээр Нэргүйн Мягмар, Цэцэгмаагийн Уртнасан нарыг томилсугай.

2.Бүрэн эрхийн хугацаа дуусгавар болсон Барсүрэнгийн Баасандоржийг Сонгуулийн ерөнхий хорооны гишүүнээс чөлөөлсүгэй.

3.Энэ тогтоолыг 2026 оны 06 дугаар сарын 30-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

С.БЯМБАЦОГТ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2026 оны 07 дугаар
сарын 02-ны өдөр

Дугаар 48

Улаанбаатар
хот

Монголбанкны Тэргүүн дэд ерөнхийлөгчийг томилох тухай

Төв Банк /Монголбанк/-ны тухай хуулийн 26 дугаар зүйлийн 2, 8 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 111 дүгээр зүйлийн 111.2 дахь хэсэг, санал хураалтын дүнг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Энхболдын Анарыг Монголбанкны Тэргүүн дэд ерөнхийлөгчөөр томилсугай.

2.Энэ тогтоолыг 2026 оны 07 дугаар сарын 02-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

С.БЯМБАЦОГТ



Үсдүгдэлтэй хамт үзүүлж байгаа үзүүлэлт

Үсдүгдэлтэй хамт үзүүлж байгаа үзүүлэлт 2026 он 12-р сард үзүүлж байгаа үзүүлэлт

Үсдүгдэлтэй хамт үзүүлж байгаа үзүүлэлт
Үсдүгдэлтэй хамт үзүүлж байгаа үзүүлэлт

Үсдүгдэлтэй хамт үзүүлж байгаа үзүүлэлт 2026 он 12-р сард үзүүлж байгаа үзүүлэлт
Үсдүгдэлтэй хамт үзүүлж байгаа үзүүлэлт 2026 он 12-р сард үзүүлж байгаа үзүүлэлт
Үсдүгдэлтэй хамт үзүүлж байгаа үзүүлэлт 2026 он 12-р сард үзүүлж байгаа үзүүлэлт

Үсдүгдэлтэй хамт үзүүлж байгаа үзүүлэлт 2026 он 12-р сард үзүүлж байгаа үзүүлэлт

Үсдүгдэлтэй хамт үзүүлж байгаа үзүүлэлт 2026 он 12-р сард үзүүлж байгаа үзүүлэлт

Үсдүгдэлтэй хамт үзүүлж байгаа үзүүлэлт
Үсдүгдэлтэй хамт үзүүлж байгаа үзүүлэлт

Үсдүгдэлтэй хамт үзүүлж байгаа үзүүлэлт

Хаяг:

“Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн редакц
Улаанбаатар-14201, Төрийн ордон 124 тоот
И-мэйл: turiin_medecelel@parliament.mn

Утас: 262420

Хэвлэлийн хуудас: 2.5

Индекс: 200003

